

ГАЗАР ДООРХ ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 20 ... ОНЫ СУДАЛГАА

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

	код	
Дүүргийн нэр:		
Хорооны дугаар:		

1. Хорооны Засаг дарга нь жил бүрийн 12-р сарын 20-ны дотор дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ судалгааг хороогоор нэгтгэн УБ хотын ЗАА-нд 12-р сарын 25-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Шугам сүлжээн дээр байрлах худгийн төрөл	МД	Хорооны нутаг дэвсгэрт байгаа худгийн тоо	Үүнээс таггүй худгийн тоо
А	Б	1	2
Дулааны худаг	1		
Цэвэр усны худаг	2		
Бохир усны худаг	3		
Холбооны худаг	4		
Борооны ус зайлуулах худаг, шүүр	5		
Бусад	6		
Нийт дүн, мөр 7= мөр\1:6\			

Балансын шалгалт: багана 2 ≤ багана 1

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

20 ... оны ... р сарын ...

Газар доорх инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын жилийн судалгааны маягт (ЭАБ-13) - ыг нөхөх заавар

Энэ судалгааг гаргахдаа хорооны ажилтан тухайн жилийн мэдээллийг 12 сарын 15-ны өдрөөр тасалбар болгон авч тогтоосон хугацаанд, цахим хэлбэрээр дүүргийн Засаг даргын тамгын газарт, дүүргийн Засаг даргын тамгын газар судалгааг хороогоор нэгтгэн, тогтоосон хугацаанд, цахим хэлбэрээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд дамжуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

2. МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

Газар доорх инженерийн шугам сүлжээнд үйлчилгээ хийх зориулалттай худгийн нээлхий нь заавал тагтай байна. Цэвэр усны хангамж, ариутгах татуурга, дулаан, холбоо, автозамын борооны ус зайлуулах шугам сүлжээн дээр ихэвчлэн ширмэн болон керамик хийцтэй таг, шүүрийг ашигладаг.

Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар нь дүүргийн ЗДТГ-т жил бүрийн эхэнд хороо бүрээр инженерийн шугам сүлжээний худгийн байрлал бүхий газрын тойм зургийг шинэчлэн хэвлэж хүргүүлнэ. Ингэхдээ холбогдох хууль тогтоомжийн дагуу дүүрэг, хорооны Засаг даргатай хамтран мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байна.

Инженерийн шугам сүлжээний худгийн тагийг гаднаас нь харж, зориулалтаар ялгахад төвөгтэй. Иймд мэргэжлийн ашиглалтын байгууллага, Ерөнхий төлөвлөгөөний газрын мэдээллийн санд ашиглах дэвсгэр зураг, түүний тэмдэглэгээг хэрэглэнэ. Үүнд:

Цахилгаан шугам нь тасархай 2 талдаа сумтай улаан шугамаар,
Дулааны шугам нь үргэлжилсэн хос улаан өнгөөр,
Цэвэр усны шугам нь үргэлжилсэн хөх өнгөөр,
Бохир усны шугам нь үргэлжилсэн ногоон өнгөөр,
Холбооны шугам нь үргэлжилсэн ягаан өнгөөр,
Борооны ус зайлуулах шугам нь үргэлжилсэн ногоовтор цэнхэр өнгөөр илэрхийлэгдсэн байна.

Шугам сүлжээн дээр байрлах худгийн таг нь дугуй дүрсээр, автозамд байрлах борооны усны шугамын шүүр нь тэгш өнцөгт дүрсээр тэмдэглэгдсэн байна.

1-р мөрөнд тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байгаа шугам сүлжээн дээр байрлах дулааны худгийн тоог бичнэ.

2-р мөрөнд тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байгаа шугам сүлжээн дээр байрлах цэвэр усны худгийн тоог бичнэ.

3-р мөрөнд тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байгаа шугам сүлжээн дээр байрлах усны худгийн тоог бичнэ.

4-р мөрөнд тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байгаа шугам сүлжээн дээр байрлах холбооны худгийн тоог бичнэ.

5-р мөрөнд тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байгаа байгаа шугам сүлжээн дээр байрлах борооны ус зайлуулах худаг, шүүрний тоог бичнэ.

6-р мөрөнд дээрх төрөлд ороогүй бусад шугам сүлжээн дээр байрлах худгийн тоог бичнэ.

7-р мөрөнд шугам сүлжээн дээр байрлах бүх худгийн тоог бичин бөгөөд мөр 7 нь мөр 7-ээс мөр 6-ын нийлбэртэй тэнцүү байна.

1-р баганад хорооны нутаг дэвсгэрт байгаа шугам сүлжээн дээр байрлах худгийн тоог бичнэ.

2-р баганад 1 дүгээр баганад бичигдсэн нийт худгийн тооноос таггүй буюу онгорхой байгаа худгийн тоог гарган бичнэ.